ЭРЧИМ ХҮЧНИЙ ҮНДЭСНИЙ ТӨВ

ЗУРАГ ТӨСЛИЙН БАРИМТ БИЧИГ

МАГАДЛАЛЫН ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ

2025 оны 05 дугаар сарын 29 өдөр

Дугаар: 391/2025

Улаанбаатар хот
Утас: 77114030

Объектын нэр:	Улаабаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 33-р хороо, Баян турууны 28-66-р гудамжны гэрэлтүүлэгийн ажлын зураг төсөв **ШИФР: МЦЭ24-30**
Объектын байршил:	Улаабаатар хот. Сонгинохайрхан дүүрэг. 33-р хороо.
Хүчин чадал:	15 кВА
Захиалагч:	Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын тамгын газар
Санхүүжилтийн эх үүсвэр:	ОНХС
Зураг төслийн ерөнхий гүйцэтгэгчийн нэр:	“Монцахэр” ХХК
Регистрийн дугаар:	**РД:2857839**
Тусгай зөвшөөрлийн хүчинтэй байх хугацаа:	2022.09.05 – 2027.09.05
Ажилбарын төрөл:	ТЗ-8.4

Зураг төсөл боловсруулах үндэслэл	
Газар эзэмшүүлэх, ашиглуулах эрх, олгосон захирамж, дугаар огноо:	-
Зураг төслийн гэрээ, баталсан албан тушаалтан, дугаар, огноо:	Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын тамгын газрын дарга Д.Төмөрбаатар, Монцахэр ХХК-ийн захирал Ж.Цогоо нарын 2024 оны 10-р сарын 19-ний өдөр байгуулсан №СХД/2024/3Ү-59 тоот гэрээ
Геодезийн хэмжилт, зураглалын ажил гүйцэтгэсэн ажлын дүгнэлт, тайлан	-
Геологийн судалгаа, үнэлгээний ажил гүйцэтгэсэн ажлын дүгнэлт	-

Техникийн нөхцөл:

Техникийн нөхцөлүүд:	Олгосон байгууллага	Дугаар, огноо	Хүчинтэй байх хугацаа
Гадна цахилгаан: 1	УБЦТС	2024.11.08-ны өдрийн №01/05828/24 тоот	1 жил

Зураг төсөл боловсруулах ажлын даалгавар:

Зураг төсөл боловсруулах ажлын даалгавар:	Олгосон байгууллага	Дугаар, огноо	Хүчинтэй байх хугацаа
-	-	-	-

Зөвшөөрөлцсөн байгууллагууд:

“УБЦТС” ТӨХК-ийн ерөнхий инженер	Т.Мөнхболд
Хот байгуулалт, Хотын стандартын газар, Хот байгуулалтын инженерийн дэд бүтцийн төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн	Б.Оргил
Нийслэлийн онцгой байдлын газрын гал түймэртэй тэмцэх хэлтсийн барилгын зураг төслийн хяналтын байцаагч, ахлах хошууч	Б.Даваасүрэн
Нийслэлийн газар зохион байгуулалтын албаны даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч	Г.Мөнхбаатар

Зураг төслийн бүрэлдэхүүн:

Зургийн бүрдэл:	Зураг төслийн гүйцэтгэсэн байгууллагын нэр:	Шалгасан экспертийн нэр:
Улаабаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 33-р хороо, Баян туруууны 28-66-р гудамжны гэрэлтүүлэгийн ажлын зураг төсөл **ШИФР: МЦЭ24-30**	“Монцахэр” ХХК Шалгасан: Ж.Цогоо Гүйцэтгэсэн: Ц.Саранцогт	Б.Энхбат
Улаабаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 33-р хороо, Баян туруууны 28-66-р гудамжны гэрэлтүүлэгийн угсралтын ажлын төсөв Төсвийн дугаар №15-3/2024	Гүйцэтгэсэн: Тэргүүлэх төсөвчин Ж.Цогоо	Б.Баярмаа

Ерөнхий дүгнэлт: /Засгийн газрын 2019 оны 108 дугаар тогтоолын 5 дугаар зүйлээс/

Эрчим хүчний тоног төхөөрөмж, барилга байгууламж техникийн ерөнхий өгөгдлийн болон техник-эдийн засгийн үзүүлэлт, зураг төслийн үндсэн төлөвлөлт, техникийн шийдлийн талаар тусгасан товч тодорхойлолт:	**Барилга байгууламжийн төлөвлөлт**: “УБЦТС” ТӨХК-ний 2024.11.08-ны өдрийн №01/05828/24 тоот техникийн нөхцөлийн дагуу “Улаабаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 33-р хороо, Баян туруууны 28-66-р гудамжны гэрэлтүүлэгийн ажлын зураг төсөл”-ийг боловсруулсан байна. **Төлөвлөлтийн хүчин чадал**: - 15 кВА **Зураг төслийг шийдэл:** *Цахилгаан холболт* - 110/35/10 кВ-ын Найрамдал дэд станц, ХБ-59-ийн 10 кВ-ын Гурван булаг фидерийн АТП-5223 дэд өртөөний 0,4 кВ талын щитийг томруулан сольж, рубильник бүхий групп тоноглож бүрээстэй агаарын шугам татаж гэрэлтүүлгийн самбарыг тэжээх. *Цахилгаан дамжуулах шугам, трассын урт* - СИП-3*16+1*25 мм² (Lтр=5193 м) *Дэд станц, хуваарилах байгууламж* *Барилга, ЦДШ-ын хамгаалалтын зурвасын нөхцөл* - Цахилгаан дамжуулах шугам нь хүн оршин суудаг газраар өнгөрөх нөхцөлтэй. */Цахилгаан байгууламжийн дүрэм БД43-101-03, 2,5,71: 2,5,76/* **Тусгай заалт:** Хөдөлмөр хамгаалал, техникийн аюулгүй ажиллагаа, орчны эрүүл ахуйн байдалд тавигдах стандартын шаардлага болон норм дүрмийг баримтлан, ААД, ТАД-ын шаардлагуудыг ханган, цахилгаан байгууламжийн дүрэм БД43-101-03, MNS6522:2015 стандарт, ЭХД1-12-04-2013–ын дагуу барилга угсралтын ажлыг гүйцэтгэвэл зохино.

Эдийн засгийн үр ашиг, экологийн хор хөнөөлгүй байдал, ашиглалтын үеийн найдвартай ажиллагаа, эрчим хүчний тоног төхөөрөмж, барилга байгууламжийн нийгмийн ач холбогдол зэргийг харгалзан гаргасан хөрөнгө оруулалтын үр ашгийн талаарх дүгнэлт:	Ашиглалтын үеийн найдвартай ажиллагаа, горимыг хангаснаар байгаль орчинд учрах сөрөг нөлөө, эрсдэл, аюулаас урьдчилан сэргийлнэ. Барилга угсралтын ажлын төсвийг боловсруулсан дүн: 529,035,952 төгрөг. **Экспертийн хянасан дүн: 529,035,952** (Таван зуун хорин есөн сая гучин таван мянга есөн зуун тавин хоёр) төгрөг. Төсвийг "Монцахэр" ХХК-ийн боловсруулсан МЦЭ24-30 шифртэй зураг төслийн дагуу ЗТХС-ын 2019 оны 256-р тушаалаар батлагдсан "Автомашинаар ачаа тээвэрлэх жишиг тариф, машин механизмыг ЗТБХБС-ын 2012 оны 18-р тушаал, цалин, нэмэгдэл зардал, зохиогчийн хяналтын зардлыг БХБС-ын 2024 оны 95-р тушаал, БХБС-ын 2020 оны 30-р тушаалаар батлагдсан "Барилгын төсөв зохиох дүрэм", БХБС-ын 2021 оны 229-р тушаалаар батлагдсан "Барилгын сантехникийн ажлын суурь норм", ДБС-ын 2017 оны 114-А тушаалаар батлагдсан "Барилгын цахилгаан холбооны угсралтын ажлын төсвийн суурь норм", түүний хавсралтууд, нэмэлтүүд, БХБС-ын 2007 оны 31-р тушаалын дагуу НӨАТ-г 10%, НДШ-ийн хувь хэмжээг 14,5%, Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэнгийн боловсруулсан "Эрчим хүчний тоног төхөөрөмжийн үний лавлах" болон зах зээлийн материалын үнэ ханш зэргийг тус тус үндэслэн "Төсөв-1" программ дээр хийж гүйцэтгэв. Төслийн барилга угсралтын ажлыг хийж гүйцэтгэснээр хэрэглэгчийг тасралтгүй, найдвартай, чанартай цахилгаан эрчим хүчээр хангах нөхцөл бүрдэнэ. Цахилгаан хангамжид сонгосон тоног төхөөрөмжүүд нь эрчим хүчний салбарын техникийн норматив баримт бичгүүдийн дагуу, хөдөлмөр хамгаалал, техникийн аюулгүй ажиллагаа, норм, дүрмийн шаардлагад нийцсэн гэж холбогдох эксперт дүгнэсэн.

"Барилгын тухай" Монгол Улсын хуулийн /шинэчилсэн найруулга 2016.02.05/ 38.1.2."барилга байгууламжийн зураг төслийн холбогдох хэсгийг боловсруулсан зохиогч тухайн зураг төслийг баталгаажуулан, мэргэжлийн хариуцлага хүлээх", 38.1.3."зураг төсөл зохиогч хуулийн этгээд барилга байгууламжийн зураг төслийг хууль тогтоомж, норм, нормативын баримт бичгийн шаардлагад нийцсэн эсэхэд хяналт хийж баталгаажуулан, хариуцлага хүлээх", 39.4."Эксперт барилга байгууламжийн зураг төслийн холбогдох хэсэгт магадлалын дүгнэлт гаргаж, мэргэжлийн хариуцлага хүлээнэ", 39,5-т заасны дагуу "Экспертийн эрх бүхий хуулийн этгээд барилга байгууламжийн зураг төслийг хууль тогтоомж, норм, нормативын баримт бичгийн шаардлагад нийцсэнийг нотолж, техникийн шийдлийн талаарх дүгнэлт гаргаж, хариуцлага хүлээнэ".

"Монцахэр" ХХК-ийн боловсруулсан: Улаабаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 33-р хороо, Баян туруугын 28-66-р гудамжны гэрэлтүүлэгийн ажлын зураг төсөлд Эрчим хүчний тухай хуулийн 3.1.32; 6.1.14 дүгээр зүйл, ЭХ Сайдын 2015 оны 188 дугаар тушаалын "Эрчим хүчний барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх" журмыг үндэслэн магадлал хийх ажлыг зохион байгуулж, ерөнхий дүгнэлт бичсэн болно.

Магадлалын ерөнхий дүгнэлт экспертүүдийн дүгнэлтийн хамт хүчинтэй.

ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР Ч.ӨЮУНБОЛД

ЗУРАГ ТӨСӨЛ МАГАДЛАЛЫН
ХЭЛТСИЙН ДАРГА Н.БОЛД

ЗУРАГ ТӨСӨЛ МАГАДЛАЛЫН
ХЭЛТСИЙН ИНЖЕНЕР Д.ЭНХБОЛОР

[1]*Монгол улсын Засгийн газрын 2019 оны 108 дугаар тогтоолын Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм* ***Тав. Зураг төслийг зөвшилцөх, батлах. Зургаа. Зураг төсөлд магадлал хийх***

МАГАДЛАЛЫН ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТИЙН ХАВСРАЛТ№ 1

ЗУРАГ ТӨСЛИЙН БҮРДЛИЙН ХЭСГИЙН НЭР: СХД-ийн 33-р хороо Баруунтурууны 28-44 44-56 56-66-р гудамжны гэрэлтүүлэгийн ажлын зураг гудамжны 165ш гэрэл 0,4кВ ЦДАШ

2025 оны 04 сарын 15 өдөр

д/д	Утга	Тайлбар
1	Объектын байршил, хүчин чадал	СХД-ийн 33-р хороо Баруунтурууны 28-44 44-56 56-66-р гудамжны гэрэлтүүлэгийн ажлын зураг гудамжны 165ш гэрэл
2	Объектын нэр, Объектын шифр	СХД-ийн 33-р хороо Баруунтурууны 28-44 44-56 56-66-р гудамжны гэрэлтүүлэгийн ажлын зураг гудамжны 165ш гэрэл ажлын зураг Шифр: МЦЭ24-30-I Монцахэр ХХК
3	***Дүгнэлтийн товч утга:*** Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 108 дугаар тогтоолын 6.12-р зүйлээс	
4	6.12.1 Архитектур төлөвлөлтийн болон зургийн даалгавар, загвар зураг, эх загвар зураг /эскиз/, байгаль, цаг уурын ерөнхий өгөгдлүүдийг тодорхойлсон, техникийн нөхцөлтэй эсэх;	Зураг төсөл боловсруулах даалгавар, техникийн нөхцлийн дагуу гүйцэтгэсэн.
5	6.12.2 Холбогдох мэргэжлийн байгууллагаар энэ дүрмийн 5.2-т заасны дагуу хянуулж, дүгнэлт гаргуулж баталгаажуулсан эсэх;	~~Ажлын зураг төслийг~~ Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн ерөнхий инженер Т.Мөнхболд Нийслэлийн газар зохион байгуулалтын албаны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Мөнхбаатар Нийслэлийн онцгой байдлын газрын ГТТХ-ын барилгын зураг төслийн хяналтын байцаагч Б.Даваасүрэн Хот байгуулалт хотын стандартын газрын ХБИДБТХ-ийн цахилгаан хангамж хариуцсан мэргэжилтэн Б.Оргил ~~зөвшилцсөн байна.~~
6	6.12.3. Барилга байгууламжийн архитектур төлөвлөлт, барилга бүтээц, инженерийн хангамжийн шийдэл нь норм, нормативын баримт бичиг, технологийн даалгавар, тоног	Техникийн тоног төхөөрөмжийн сонголт нь Монгол улсад мөрдөгдөж байгаа норм дүрэм, стандарт, техникийн шаардлагыг хангасан.

	төхөөрөмжийн паспорт, инженер-геологийн судалгааны дүгнэлт, техникийн нөхцөлийн дагуу боловсруулсан эсэх;	
7	6.12.4. Хөдөлмөрийн аюулгүй байдал, техник технологийн аюулгүй ажиллагаа, орчны эрүүл ахуйн норм, нормативын баримт бичгийн шаардлагыг хангуулсан эсэх;	Сонгож авсан тоног төхөөрөмж нь хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны стандарт шаардлагыг хангасан байна.
8	6.12.5. Барилгын ажлын талбай, үйлдвэрлэлийн зохион байгуулалтын зураг төсөлд хөдөлмөрийн аюулгүй байдал, техник технологийн аюулгүй ажиллагааны нөхцөл шаардлагыг тусгасан эсэх;	Хөдөлмөр хамгаалалын аюулгүй байдлыг бүрэн хангасан.
9	6.12.6. инженерийн хангамжийн хувилбар, харьцуулсан тооцоо, сонгосон хувилбарын талаарх дүгнэлттэй эсэх;	Шаардлагатай тооцоог хавсаргасан байна.
10	6.12.7. хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хэрэгцээ, техникийн шаардлагыг хангуулсан эсэх;	Шаардлагагүй
11	6.12.8. эдийн засгийн үр ашиг, экологийн хор хөнөөлгүй байдал, ашиглалтын үеийн найдвартай ажиллагаа, барилга байгууламжийн нийгмийн ач холбогдол зэргийг харгалзан хөрөнгө оруулалтын үр ашгийн талаарх дүгнэлт гаргасан эсэх;	Эдийн засгийн үр ашиг, экологийн хор хөнөөлгүй, ашиглалтын үеийн найдвартай ажиллагаа, барилга байгууламжийн нийгмийн ач холбогдол хандагдсан
12	6.12.9. зураг төслийн сонгосон шийдэл, магадлал хийх явцад экспертээс өгсөн нэмэлт, өөрчлөлтийн саналыг зураг төсөлд тусгасан эсэх.	Экспертээс өгсөн саналуудыг зураг төсөлд тусгасан.

Дүгнэлт бичсэн:

Эксперт № 11-9 Б.Энхбат ...инженер... /

МОНГОЛ УЛС 23-1702 АТХ9751 Баярсайханы ЭНХБАТ ЗӨВЛӨХ ИНЖЕНЕР ЗТ-ЦХ

2025 оны 04 сарын 15 өдөр

Зураг төслийн бичиг баримтын

МАГАДЛАЛЫН ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТИЙН ХАВСРАЛТ №2

ЗУРАГ ТӨСЛИЙН БҮРДЛИЙН ХЭСГИЙН НЭР

2025 оны 04 сарын 10 өдөр

д/д	Экспертийн санал, илэрсэн алдаа, зөрчил	Биелэлт
1	Зургийн ажлын тоо хэмжээ техникийн нөхцөлөөс давсан байна.	Баянтуругийн гудамжинд 3 хуваасан, Зүйлийн хэмжээний тоог бууруулсан.
2	Хүчдлийн уналтыг тооцоогоор баталгаажуулах	Хийсэн.
Биелэлтийг шалгасан: Эксперт № 11-9 / Б.Энхбат /		/ /
Биелэлт гаргасан: / / Ж.Цогоо / Ж.Цогоо		

МОНГОЛ УЛС 23-1702 АТХ9751 Баярсайхан ЭНХБАТ ЗӨВЛӨХ ИНЖЕНЕР ЗТ-ЦХ 2023-2028

Эрчим хүчний үндэсний төвийн гүйцэтгэх захирлын 20 оны дүгээр сарын -ний өдрийн тоотын тушаалын гуравдугаар хавсралт

Зураг төслийн бичиг баримтын

МАГАДЛАЛЫН ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТИЙН ХАВСРАЛТ №1

ЗУРАГ ТӨСЛИЙН БҮРДЛИЙН ХЭСГИЙН НЭР

2025 оны 05 сарын 28 өдөр

д/д	Утга	Тайлбар
1	Объектын нэр, объектын шифр	Баруунтурууны 28-66-р гудамжны гэрэлтүүлэгийн ажлын зураг МЦЭ24-30
2	Объектын байршил, хүчин чадал	Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 33 хороо, Баян турууны 28-44, 44-56, 56-66-р гудамжны гэрэлтүүлгийн ажлын төсөв. 165ш гэрэл,
3	***Дүгнэлтийн товч утга:*** Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 108 дугаар тогтоолын 6.12-р зүйлээс	
4	6.12.1 Архитектур төлөвлөлтийн болон зургийн даалгавар, загвар зураг, эх загвар зураг /эскиз/, байгаль, цаг уурын ерөнхий өгөгдлүүдийг тодорхойлсон, техникийн нөхцөлтэй эсэх;	Зураг төсөл боловсруулах даалгавар, техникийн нөхцөлтэй.
5	6.12.2 Холбогдох мэргэжлийн байгууллагаар энэ дүрмийн 5.2-т заасны дагуу хянуулж, дүгнэлт гаргуулж баталгаажуулсан эсэх;	Ажлын зургийн шифр: МЦЭ24-30-I, МЦЭ24-30-II, МЦЭ24-30-III, Захирал: Ж.Цогоо Гүйцэтгэсэн инженер: Ц.Саранцогт Шалгасан: Ж.Цогоо Төсөв зохиосон: Ж.Цогоо Ажлын зураг төсөлд магадлал хийсэн: зөвлөх инженер Б.Энхбат.
6	6.12.3. Барилга байгууламжийн архитектур төлөвлөлт, барилга бүтээц, инженерийн хангамжийн шийдэл нь норм, нормативын баримт бичиг, технологийн даалгавар, тоног төхөөрөмжийн паспорт, инженер-геологийн судалгааны дүгнэлт, техникийн нөхцөлийн дагуу боловсруулсан эсэх;	
7	6.12.4. Хөдөлмөрийн аюулгүй байдал, техник технологийн аюулгүй ажиллагаа, орчны эрүүл ахуйн норм,	

	норматывын баримт бичгийн шаардлагыг хангуулсан эсэх;	
8	6.12.5. Барилгын ажлын талбай, үйлдвэрлэлийн зохион байгуулалтын зураг төсөлд хөдөлмөрийн аюулгүй байдал, техник технологийн аюулгүй ажиллагааны нөхцөл шаардлагыг тусгасан эсэх;	
9	6.12.6. инженерийн хангамжийн хувилбар, харьцуулсан тооцоо, сонгосон хувилбарын талаарх дүгнэлттэй эсэх;	
10	6.12.7. хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хэрэгцээ, техникийн шаардлагыг хангуулсан эсэх;	
11	6.12.8. эдийн засгийн үр ашиг, экологийн хор хөнөөлгүй байдал, ашиглалтын үеийн найдвартай ажиллагаа, барилга байгууламжийн нийгмийн ач холбогдол зэргийг харгалзан хөрөнгө оруулалтын үр ашгийн талаарх дүгнэлт гаргасан эсэх;	1. Төсөв дугаар 15-1/2024 ажлын төсөвт өртгийг 193,790,341 (Нэг зуун ерэн гурван сая долоон зуун ерэн мянга гурван зуун дөчин нэг) төгрөг, 2. Төсөв дугаар 15-2/2024 ажлын төсөвт өртгийг 178,058,778 (Нэг зуун далан найман сая тавин найман мянга долоон зуун далан найм) төгрөг, 3. Төсөв дугаар 15-3/2024 ажлын төсөвт өртгийг 157,183,833 (Нэг зуун тавин долоон сая нэг зуун гурван мянга найман зуун гучин гурав) төгрөгөөр тус тус хяналаа.
12	6.12.9. зураг төслийн сонгосон шийдэл, магадлал хийх явцад экспертээс өгсөн нэмэлт, өөрчлөлтийн саналыг зураг төсөлд тусгасан эсэх.	

Дүгнэлт бичсэн:

Эксперт №14-5 / Б.Баярмаа /

2025 оны 05 сарын 28 өдөр

Зураг төслийн бичиг баримтын

МАГАДЛАЛЫН ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТИЙН ХАВСРАЛТ №2

ЗУРАГ ТӨСЛИЙН БҮРДЛИЙН ХЭСГИЙН НЭР

2025 оны 04 сарын 17 өдөр

д/д	Экспертийн санал, илэрсэн алдаа, зөрчил	Биелэлт
1	Төсвийн товч тайлбар /Хавсралт 17Б/ -г бүрэн хөтлөх, төсөв тооцсон үндэслэлийг зөв тодорхойлох. Жишээ нь: Ерөнхий захиалагч, цалин болон тээвэр тооцсон үндэслэл, материалын тээврийг хэдэн км-т тооцсон, ямар программ хангамж ашигласан гэх мэт.	Төсөв-1 программ дээр төсөв хийсэн.
2	Төсвийн шифр, дугаарын ойлгомжтой дарааллуулж өгөх. Нэг багц зургын ажлыг 3 бүлэг болгосон байхад 15-1/2024, 16/2024, 15-3/2024 гэж дугаар олгосон нь ойлгомжгүй байна.	Төсвийн шифрийг засав. 15-1, 15-2, 15-3 болгов.
3	Төсөвт өртгийн товчооны бодолтыг хянах. Жишээ нь: Нэмэгдэл зардал 86.5%, Төсөвт ашиг 15% гэх мэт.	Засав.
4	Ган болон хуванцар хоолой угсрах ажлын үндэслэлийг зөв сонгох. Хэмжих нэгжийг зөв тодорхойлох.	Засав.
5	Газардуулгын шин болон гадас зоож шинтэй холбох угсралтын ажлын үндэслэлийг зөв сонгох.	Засав.
6	Нүх, шуудуу ухах ажлын үндэслэлийг зөв сонгох	Засав, 97%, 3% болгов.
7	Газар шорооны ажлыг "Барилгын ажлын тоо хэмжээ бодох аргачилсан заавар"-ын дагуу механизмаар болон гараар гүйцэтгэх.	Засав.
8	Материалын нэршилийг зурагт тусгасанаар тодорхойлох	Холтос тулгав.
9	Гэрэлтүүлгийн ерөнхий самбарын тэжээлийн кабелийн угсралтын ажлын төсвийг зургийн дагуу хийх.	Кабелийн төсөвийг бүрэн болгож хийв.
10	Машин механизмын тооцооллын машин ашиглалтын нэг машин - цагийн жишиг үнийг тулгах, засах.	Тулгаж засав.
11	Төсөвт тусгагдсан материалуудын жинг зурагтай тулгах, засах. Жиш: Гэрэлтүүлэгчийн толгой, ган хоолой, газардуулгын шин, гадас гэх мэт.	Тулгаж засав.

12	Төсвүүдийг бүхэлд нь ажлын зурагтай тулгах, ажлын тоо хэмжээ, материалын тоо хэмжээ зургаас зөрж байгааг засах. Зурагт тусгагдаагүй материал төсөвт орсон байна.	Тумаж, засав.
13	Төсөв 15-3/2024 бүхэлдээ ажлын зургаас зөрсөн байгааг засах.	Тумаж засав.
14	АТП-5223 дэд станцын 0.4 кВ-ын шит томруулах ажлын төсөв зохиох.	Юмж оруулав.

Биелэлтийг шалгасан:
Эксперт № 14-5 / Б.Баярмаа / /

Биелэлт гаргасан: / Ж. Цогоо / Ж. Цогоо

УЛААНБААТАР ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИ

ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ

Дугаар 01/05828/24

2024 оны 11 сарын 8 өдөр Улаанбаатар хот

Нэг. Ерөнхий мэдээлэл

1.1	**Хүсэлтийн дугаар**	*241001082*
1.2	**Хэрэглэгчийн нэр, регистр:**	*СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР, РД:9091904*
1.3	**Хэрэглэгчийн байршил:**	*Улаанбаатар Сонгинохайрхан 33-р хороо Баянтуруун -16*
1.4	**Ажил үйлчилгээний зориулалт:**	*Нийтийн эзэмшлийн гэрэлтүүлэг*
1.5	**Техникийн нөхцөл олгох үндэслэл:**	*1.5.1) Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын тамгын газрын 2024-10-08-ны өдрийн №03/2787 тоот хүсэлт*
1.6	**Техникийн нөхцөлийн ангилал:**	*Шинэ холболт*
1.7	**Суурилагдсан хүчин чадал**	*15 кВА* *(Арван таван кВА)*
1.8	**Хүчдэлийн түвшин**	*380В*

Хоёр. Холболтын цэг

2.1	110/35/10 кВ-ын Найрамдал дэд станц, ХБ-59-ийн 10 кВ-ын Гурван булаг фидерийн АТП-5223 дэд өртөөний 0.4 кВ талын щитийг томруулан сольж, рубильник бүхий групп тоноглож бүрээстэй агаарын шугам татаж гэрэлтүүлгийн самбарыг тэжээх. /СХД, 33-р хороо Баян туруун 28-44 гудамж, 70 ширхэг гэрэлтүүлэг/

Гурав. Тоолуур, хэмжих хэрэгсэл:

3.1	Монгол Улсын Засгийн газрын тохируулагч агентлаг-Стандарт, хэмжилзүйн газрын загварын туршилт орон, ашиглахыг зөвшөөрч, баталгаажуулсан байх.
3.2	Гэрэлтүүлгийн 0.4 кВ-ын щитэнд 25 А-ийн дифференциал автомат болон хамгаалан таслах төхөөрөмж /УЗО/ суурилуулах, УБЦТС ТӨХК-д ашиглагдаж байгаа ухаалаг тоолуурын системд холбогдон ажилладаг, DLMS протоколыг дэмждэг, 4G модемтой, чадал хязгаарлах функцтай, алсаас таслах залгах зориулалттай, 3 фазын 100 А-ийн ухаалаг тоолуур суурилуулах.

Дөрөв. Тусгай заалтууд:

4.1	Щитний газардуулга болон шугам тоноглолын хэмжилт, туршилтыг норм,

дүрмийн дагуу хийлгэн холбогдох газраар шалгуулж протокол авсан байх.

4.2 Энэхүү техникийн нөхцөлийн дагуу олгогдсон 15 кВА тооцооны бүрэн чадлыг хэтрүүлэн хэрэглэсэн нь нотлогдвол техникийн нөхцөлийг цуцлах болно.

4.3 Гадны ээмшлийн дэд өртөө 0.4 кВ-ын шугамаас холбогдох тохиолдолд тус дэд өртөө шугамын эзэмшигчээс зөвшөөрөл авсан байх.

4.4 Шугам тоноглолын гүйцэтгэлийн зургийг гаргаж, ашиглагч байгууллага УБЦТС ТӨХК-д хүлээлгэн өгөх, гүйцэтгэлийн зургийг гаргахдаа кабель шугамын холболтын муфтуудыг заасан, бусад инженерийн шугам сүлжээ, авто замтай огтлолцсон хэсгийн зүсэлтийг тусгах.

4.5 Цахилгаан дамжуулах агаарын шугамын тулгуур бүрт НСД, ААД, ТАД-д заагдсаны дагуу хаягжилт, плакатжуулах ажлыг гүйцэтгэсэн байна.

4.6 Хэрэглэгчийн эрчим хүчний чанар, стандартын шаардлага хангахгүй тохиолдолд хүчдэл өргөх болон техникийн нэмэлт арга хэмжээнүүдийг хангагч байгууллагатай хамтарсан хэмжилт туршилтын үндсэн дээр хэрэгжүүлнэ. Гарах зардлыг хэрэглэгч бүрэн хариуцна.

4.7 Барилга угсралтын ажлын зураг нь ЦБД, ТАД, ААД, ЭХ-ний шугам сүлжээг хамгаалах дүрэм, ЭХ хэрэглэх дүрэм болон УБЦТС ТӨХК-аас хэрэгжүүлж байгаа ашиглалт борлуулалтын арга хэмжээний шаардлагуудыг хангасан байна.

4.8 Өөрийн шугам тоноглолоос хангагчийн зөвшөөрөлгүйгээр бусад хэрэглэгчийг дамжуулан холбосон тохиолдолд цахилгаан хангамж, хэрэглээг түдгэлзүүлнэ.

4.9 Шинээр баригдах цахилгаан дамжуулах кабель шугам нь:

4.9.1) Шинээр татах кабель шугамын хөндлөн огтлолыг хэрэглээ ачаалалтай уялдуулан зураг төслийн шатанд тооцоогоор сонгох.

4.9.2) Цахилгаан дамжуулах кабель шугам нь 1 кВ-ын хүчдлийн түвшинд ашиглах, орчны температур -15 хэм байхад угсралт хийх боломжтой байх.

4.10 Шинээр баригдах цахилгаан дамжуулах агаарын шугам нь:

4.10.1) Цахилгаан дамжуулах агаарын шугамын үндсэн хийц болох анкер болон завсрын тулгуур нь төмөр бетон байх.

4.10.2) Дамжуулагч нь бүрээстэй байх ба хөндлөн огтлолыг ачаалалтай уялдуулан, тооцоогоор сонгох, мөн утасны механик ачаалалд тохирсон үндсэн хийцүүд, хөндийрүүлэгч элементүүдийг тооцоогоор сонгох.

4.11 Цахилгаан дамжуулах агаарын шугамын үндсэн хийцүүд, дамжуулагч утас, хөндийрүүлэгч элементүүд, утас угсралтын тоног төхөөрөмжүүд нь Монгол улсын стандартын шаардлага хангасан байх, тухайн газрын байгаль цаг уур, газарзүйн онцлогийг харгалзан зураг төслөөр сонгох.

4.12 Дэд өртөөний трансформатораас 0.4 кВ-ын шитний оруулгын кабелийг 240 мм2 хөндлөн огтлолтой болгон солих, тус ажлыг харьяа түгээх төвөөр гүйцэтгүүлэх.

4.13 Дэд өртөөний 0.4 кВ-ын ерөнхий самбарыг 6 гаргалга бүхий самбараар томсгон солих, тус ажлыг харьяа түгээх төвөөр гүйцэтгүүлэх.

4.13.1) АТП-5223 дэд өртөөнүүдээс буусан тоног төхөөрөмж болон эдгээр дэд өртөөнд нэмж суурилуулан тоноглолыг Монгол улсын засгийн газрын 2020 оны 97- р тогтоолын 2.7.2-т заасны дагуу УБЦТС ТӨХК-ийн үндсэн хөрөнгөнд шилжүүлэн өгөх.

4.14 Техникийн нөхцөлийн дагуу шинээр суурилуулах тоноглолууд нь өмнө ашиглагдаж байгаагүй шинэ байх, кабель шугам, трансформаторууд нь сүүлийн үеийн байгаль орчинд ээлтэй, дэвшилтэд техник технологи бүхий байх. Нэгдсэн сүлжээний дүрэмд заасны дагуу ±10%-ийн хүчдлийн хэлбэлзэлд хэвийн ажиллах.

Тав. Дор дурдсан техникийн даалгавар, хууль дүрмийг мөрдөх:

5.1	Шугамын “Ажлын зураг төсөл”-ийг тухайн нутаг дэвсгэрийн ерөнхий төлөвлөгөө хариуцсан нэгж болон бусад шаардлагатай байгууллагуудтай зөвшилцөн, мэдээллийн санд оруулсан байх, схем холболт, хүчин чадлыг тус компаниар хянуулах.
5.2	Энэхүү техникийн нөхцөлийн дагуу тавигдах шугам, тоноглолууд нь Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ төрийн өмчит хувьцаат компанийн баталсан “Техникийн шаардлагын тодорхойлолт”-ыг хангасан байх шаардлагатай. Техникийн шаардлагын тодорхойлолтыг www.tog.mn хаягаар орж хууль, дүрэм цонхноос үзэх.
5.3	Цахилгаан шугам сүлжээнд холбогдох явцад дайрч гарах зам талбай, бут сөөгийг сэргээн засварлах.
5.4	“Эрчим хүчний тухай” хуулийн 29.1.9, 30.1.10-ийн дагуу өөрийн тоноглолоос тус компанийн зөвшөөрлөөр шинээр хэрэглэгч нэмж холбуулах.
5.5	“Эрчим хүчний тухай хууль”-ийн 30.1.8-д заасны дагуу өөрийн ашиглалт үйлчилгээний зааг доторхи цахилгаан тоног төхөөрөмжиндөө байнга үзлэг шалгалт хийх. Хэвийн бус ажиллагаатай үед өөрсдийн хөрөнгөөр засвар үйлчилгээг хийлгэх.
5.6	“Эрчим хүчний тухай” хуулийн 33 дугаар зүйлд заасны дагуу шугам сүлжээний хамгаалалтын зурвас дотор гэр, орон сууц, барилга байгууламж барих, шугам сүлжээ өмчлөгч, эзэмшигчийн зөвшөөрснөөс бусад үйл ажиллагаа явуулахыг хориглоно.
5.7	Нийслэлийн нутаг дэвсгэрт кабель шугам шинээр татах, шинэчлэх, засварлах үед авто зам, ногоон байгууламж, нийтийн эзэмшлийн тохижилттой зам талбайг сэтлэх, сүвлэх инженерийн шугам сүлжээ хийх, орц гарц гаргах тохиолдолд Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанаас зөвшөөрөл авах.
5.8	Угсралтын ажлын явцад тус компанийн харьяа түгээх төвөөр хяналт тавиулж, холбогдох баримтыг бүрдүүлсэн байх.
5.9	Цахилгаан угсралтын ажлыг тусгай зөвшөөрөлтэй эрх бүхий байгууллагаар Аюулгүй ажиллагааны дүрэм, Техник ашиглалтын дүрэм, Цахилгаан байгууламжийн дүрмийн дагуу гүйцэтгүүлэх.
5.10	Цахилгаан эрчим хүчний тооцоог Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ төрийн өмчит хувьцаат компанийн харьяа хэрэглэгчдэд үйлчлэх төвтэй хийх.

Зургаа. Бусад:

6.1	Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 97 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрэм”-ийн 2.17-д заасан доорх заалтуудыг мөрдлөг болгоно. Дараах тохиолдолд олгосон техникийн нөхцөлийг хүчингүйд тооцно. Үүнд: 6.1.1) Техникийн нөхцөл авахдаа шаардлагатай өгөгдлүүдийг буруу тодорхойлсон, баримт бичгийг хуурамчаар үйлдсэн тохиолдолд. 6.1.2) Холболт хийх цэгийн хүчин чадлаас хэтрүүлэн техникийн нөхцөл олгосон. 6.1.3) Техникийн нөхцлийн хүчинтэй байх хугацаанд цахилгааны сүлжээнд холбогдоогүй тохиолдолд. 6.1.4) Хугацаа дууссан техникийн нөхцөлөөр зураг төсөл боловсруулах, барилга байгууламж барихыг хориглоно. 6.1.5) Техникийн нөхцөлийн хүчинтэй хугацаа дуусахаас 1 сарын өмнө сунгуулах

	хүсэлтээ гаргана. Хугацаа дууссан техникийн нөхцөлийг хүчингүй тооцно. 6.1.6) Техникийн нөхцөлийн олгосон чадлаас хэтрүүлэн чадал ашигласан тохиолдолд.
6.2	Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 97 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрэм”-ийн 2.9-д заасны дагуу 1 жилийн хугацаанд хүчинтэй байна.
6.3	Техникийн нөхцөлийн хугацааг сунгуулах тохиолдолд Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 97 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрэм”-ийн 2.13, 2.16-д заасны дагуу зураг төслийг боловсруулан баталгаажуулсан байна.